Тайлант онд батлагдсан төсвийг 59,690.6 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,070,737.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Тайлант онд 1,283.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,047,039.1 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	619,101.2	614,704.5	5,339.3	99.3%
2	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Баг хорооны ҮА-ны зардал-80106	132,240.6	130,079.2	2,161.4	98.4%
3	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	85,680.1	84,390.9	1,289.2	97.0%
4	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Нийтлэг үйлчилгээ-80112	59,681.3	59,490.0	191.3	99.7%
5	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Мэдээлэл, сурталчилгааны зардал-80205	6,500.0	5,500.0	1,000.0	84.6%
6	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	43,354.5	43,008.9	345.6	99.2%
7	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Орон нутгийн нөөц хөрөнгө-81102	24,500.0	24,442.4	57.6	99.8%
8	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Мал тооллого- 81507	750.0	0	750.0	0%
9	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Хур хог хаягдал орчны бохирдол- 82212	2,077.8	1,000.0	1,077.8	48.1%
10	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Улсын их баяр наадам- 82801	5,000.0	5,000.0	0.0	100%
11	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх-71413 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх-81701	87,251.5	76,577.4	10,674.1	87.8%
12	Ахмад насны хөгжил хамгаалал-72208 Ахмадын сан-81549	4,600.0	2,845.8	1,754.2	61.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

## Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	4,905.0	Тайлант онд Санхүүгийн СИ ТЭ ЭС программ 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч ашиглаж эхэлсэн байна.
2	Унаа, хоолны зардал	0.0	Унаа, хоолны зардал олгоогүй байна.
3	Сургалт, семинар	18,000.0	Тайлант онд 4 удаагийн сургалт хэлэлцүүлэг, баруун бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	5,500.0	Зурагтын түүхэн нэвтрүүлэг, нэвтрүүлгийн хөлс
7	Орон тоо	660,966.8	Тайлант онд 21 орон тоо ажиллахаар батлагдсанаас хөдөөгийн багуудын сахиулыг гэрээт ажиллуулан 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 83,500.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,084.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,000.0 мянга, нийт 92,584.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 43,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, программ хангамж, 63,904.5 мянган төгрөгийн бараа материалыг тайлант онд шууд худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 1,387,263.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,872.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,446,840.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,468.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,574.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.4 дэх заалтад “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад 569.0 мянга, “Хөх тэнгэрийн эсгий туургатан” НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлгийн хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3,000.0 мянга, А/15 дугаар тушаалаар 1,000.0 мянга, МБСТВ ХХК-д нэвтрүүлгийн төлбөрт 2025 оны А/06 дугаар тушаалаар 1,500.0 мянга, нийт 6,069.0 мянган төгрөгийг зарцуулсанд тус тус албан шаардлага өглөө.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.2.1 дэх заалтад “Эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2 дахь заалтад “Бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь заалтад “Соёлын үйлчилгээ”, 25.2.4 дэх заалтад “Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх” гэж заасныг зөрчин аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойн хүрээнд 66,480.0 мянган төгрөгийн хандивыг Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дах хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкт хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкт хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картан данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картан дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картан дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасан байна.

Тайлант онд Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,345.2 мянган төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсанд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 171, хугацаа хоцроон байршуулсан 10, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь “Төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 07 дугаар сарын 20-ны дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг тооцоолсон байна. Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1-д “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэж заасныг баримтлан тооцож байхыг зөвлөж байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмж өгснийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 16 дугаар, 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 100 дугаар албан бичгүүдээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын fas.audit.mn цахим системд байршуулсан байна.

##### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоонд байхгүй селесерь, олон нийтийн цагдаа, хөдөөгийн багуудын сахиулыг ажиллуулж төсвөөс 70,345.8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ асуудлыг судалж шийдвэрлэсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 15,813.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 1,399.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,069.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 8,345.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

##### **5.1 Төлбөрийн акт**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь цалингийн зардлаас тухайн албан хаагчийн ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Бөхмөрөн сумын засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар төрийн сангийн мэргэжилтэн Т.Өнөржаргалд санхүүгийн аудитын шалгалтаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж 1,399.0 мянган төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь заалтад “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшуулалт цалин 1,399.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

##### **5.2 Албан шаардлага-1**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн

зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 569.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

## **Албан шаардлага-2**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь “Хөх тэнгэрийн эсгий туургатан” НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3,000.0 мянга, А/15 дугаар тушаалаар 1,000.0 мянга, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1,500.0 мянга, нийт 5,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4 дэх заалтад “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

## **5.3 Зөвлөмж**

### Илрүүлэлт: Зардлын данстай холбоотой

Тайлант онд Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,345.2 мянган төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дах хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна.

Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Цаашид байгууллагын нярвын хувийн дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь цалингийн зардлаас тухайн албан хаагчийн ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Бөхмөрөн сумын засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар төрийн сангийн мэргэжилтэн Т.Өнөржаргалд санхүүгийн аудитын шалгалтаар "зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж 1,399.0 мянган төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон байна.			1	1,399.0								
Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 569.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.					1	569.0						

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь "Хөх тэнгэрийн эсгий туургатан" НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3,000.0 мянга, А/15 дугаар тушаалаар 1,000.0 мянга, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1,500.0 мянга, нийт 5,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.					1	5,500.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>7,468.0</b>	<b>1</b>	<b>1,399.0</b>	<b>2</b>	<b>6,069.0</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,345.2 мянган төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан байна.	1	8,345.2					1	8,345.2
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>8,345.2</b>					<b>1</b>	<b>8,345.2</b>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАН



М.БАТСУУРЫ/

М.БАТ-АМГАЛАН/

/Г.АМАРМЭНД/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/Н/А2070413  
УВА-2026/041/НА-СТА-ТШЗ

Улаангом

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь төрийн сангийн мэргэжилтэн Т.Өнөржаргалын ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Бөхмөрөн сумын засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар санхүүгийн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж 1,399,000 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь заалтад “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, тэтгэмжийг олгох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон урамшуулал 1,399,000 /Нэг сая гурван зуун ерэн есөн мянга/ төгрөгийг Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын даргаар ажиллаж байсан Н.Баттулга, Засаг даргын тамгын газрын төсөв төрийн сангийн мэргэжилтэнээр

ажиллаж байсан Т.Өнөржаргал, нягтлан бодогч Х.Саруул-Эрдэнэ нараар төлүүлж МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяр, нягтлан бодогч Х.Саруул-Эрдэнэ нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/14/АУДТ0413  
УВА-2026/041/НА-СТА-ТШ13

Улаангом

Зөрчил давтан гаргахгүй  
байх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь “Хөх тэнгэрийн эсгий туургатан” НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар 3,000.0 мянга, А/15 дугаар тушаалаар 1,000.0 мянга, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1,500.0 мянга, нийт 5,500.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4 дэх заалтад “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвөөс хуулиар хориглосон зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар<sup>2</sup> т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөхмөрөн сумын Засаг дарга П.Баярсайхан, Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяр, нягтлан бодогч Х.Саруул-Эрдэнэ нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.АМАРМЭНД

М.БАТ АМГАЛАН

М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 02/15/А.2070413  
УВА-2026/041/НА-СТА-ТЦЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 569.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.6 дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр хуулиар хориглосон зардал буюу бэлэг худалдан авахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар<sup>2</sup> т ирүүлэх.

<sup>2</sup>Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525090073

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөхмөрөн сумын Засаг дарга П.Баярсайхан, Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяр, нягтлан бодогч Х.Саруул-Эрдэнэ нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

